



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/49

Чингис хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.3-ын "н" дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариалангийн зориулалтаар газар эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж, нэгж талбарын хувийн хэрэгт хяналт, шалгалт хийж дүгнэлт гаргах ажлыг Батноров, Дадал, Хэрлэн, Жаргалтхаан, Дэлгэрхаан сумдад 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс 2021 оны 2 дугаар сарын 8-ны өдөр, бусад сумдад 2021 оны 2 дугаар сарын 26-ны өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Дарханбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Билэгсайхан	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга
Гишүүд:	Г.Мөнх-Эрдэнэ	Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Уул уурхай, тусгай хамгаалалттай газар нутаг хариуцсан мэргэжилтэн
	Г.Баянзул	Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга Сумдын газрын даамал

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Б.Дарханбаатар/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010149